

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 27 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны аравдугаар сарын 9-ний 14 цаг 18 минутад эхэлж, 15 цаг 48 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 30 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	УИХ-ын Тамгын газар, Стандартчилал, хэмжил зүйн газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. УИХ-ын Тамгын газар, Стандартчилал, хэмжил зүйн газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 65 иргэнийг “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх.2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 4 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 4 нэр

		<p>иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тус тусын албан тушаалд томилохыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга /Б.Болдбаатар/-т, Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга /Г.Гантөмөр/-т тус тус үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “б”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Чойндонгийн Даваажамцыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологийн хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт хүргүүлэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд Төрийн албаны зөвлөлийн</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд</p>

	дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "а"-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Бодьгэрэлийн Цэндсүрэнг Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Архангай аймгийн Засаг даргаар 2004-2008 онд ажиллаж байсан Ж.Хүрэлсүхийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Архангай аймгийн Засаг даргаар 2004-2008 онд томилогдон ажиллаж байсан Жигмэдцэдэнгийн Хүрэлсүхийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	<p>Говь-Алтай аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 1/1596 тоот албан бичгээр Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, 2014 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>

6	Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга Т.Болдбаатарын 2014 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 1/452 тоот албан бичгээр ирсэн Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай хүсэлтийг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
7	Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгийн 2014 оны 9 дүгээр сарын 24-ны өдрийн ХЭГ/1600 тоот албан бичгээр Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга ирүүлснийг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
8	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Мэдээллийн технологи, инновацийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаагийн 2014 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 1/891 тоот албан бичгээр Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Мэдээллийн технологи, инновацийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд

		нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
9	Төрийн албаны зөвлөлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг өөрчлөн томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2014 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 14/12 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Рагчаагийн Өнөрсайханыг 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн томилох.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 10-т “...Лхагвын Содчимэг ” гэснийг “....Рагчаагийн Өнөрсайхан” гэж өөрчлөх.</p> <p>3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Р.Өнөрсайханд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

